



БАГАНУУР ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС



Танаа

БАГАНУУР ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН БАЙДАЛ

/2014 оны эхний 7 сар/

/албан ёсны статистик мэдээллээр бэлтгэсэн танилцуулга/

2014 он

**ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН
ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД**



Хүснэгт 1. Жил бүрийн эхний 7 сарын байдлаар

| | Хэмжих нэгж | 2008 | 2009 | 2010 | 2011 | 2012 | 2013 | 2014 |
|------------------------|----------------|-------|-------|-------|-------|-------|-------|------|
| Суурин хүн ам | Тоо | 28577 | 25875 | 26905 | 27036 | 27440 | 27936 | |
| Шинээр төрсөн хүүхэд | Тоо | 404 | 410 | 378 | 342 | 409 | 468 | 454 |
| Нас баралт | Тоо | 112 | 92 | 101 | 115 | 90 | 108 | 111 |
| Шилжиж ирсэн | Тоо | 628 | 568 | 780 | 476 | 423 | 561 | 569 |
| Шилжиж явсан | Тоо | 1014 | 856 | 936 | 578 | 478 | 596 | 591 |
| Ажилгүйчүүд | Тоо | 371 | 587 | 727 | 559 | 438 | 481 | 393 |
| Халдварт өвчин | Тоо | 536 | 332 | 307 | 320 | 344 | 366 | 256 |
| Бүртгэгдсэн гэмт хэрэг | Тоо | 191 | 182 | 169 | 156 | 169 | 180 | 142 |

АЖ ҮЙЛДВЭР: Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний нийт үйлдвэрлэлт 2014 оны эхний 7 сарын байдлаар 54324.9 сая төгрөгт хүрч өнгөрсөн оны мөн үеэс 1.2 хувиар буюу 658.0 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 2. Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт

| Үзүүлэлт | Нийт үйлдвэрлэлт /биет хэмжээгээр/ | | | Нийт үйлдвэрлэлт /үнийн дүнгээр, мянган төгрөг/ | | |
|-------------------------|---------------------------------------|---------|------------------|--|------------|------------------|
| | 2013 он | 2014 он | өсөлт бууралт | 2013 он | 2014 он | өсөлт бууралт |
| Нүүрс олборлолт | 2070.1 | 1834.4 | -235.7 | 42437050.0 | 41274000.0 | -1163050.0 |
| Дулаан дамжуулалт | 92.0 | 93.8 | 1.8 | 1713422.3 | 1801401.9 | 87979.6 |
| Талх үйлдвэрлэлт | 40.8 | 50.7 | 9.9 | 51521.7 | 64705.8 | 13184.1 |
| Нарийн боов үйлдвэрлэлт | 63.8 | 84.2 | 20.4 | 135602.5 | 178251.2 | 42648.7 |
| Арматур | 10885.0 | 11067 | 182.0 | 10645350.0 | 11006540.0 | 361190.0 |



Тайлант хугацааны аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийг /биет хэмжээгээр/ өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад талх үйлдвэрлэлт 24.3 хувиар буюу 9.9 тонноор, нарийн боов үйлдвэрлэлт 32.0 хувиар буюу 20.4 тонноор, дулаан дамжуулалт 2.0 хувиар буюу 1.8 мянган гкал-аар, арматур үйлдвэрлэлт 1.7 хувиар буюу 182.0 тонноор тус тус өссөн бол нүүрс олборлолт 11.4 хувиар буюу 235.7 мянган тонноор буурсан байна.



Харин аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийг үнийн дүнгээр өнгөрсөн оны мөн үетэй харьцуулж үзэхэд дулаан дамжуулалт 5.1 хувиар буюу 88.0 сая төгрөгөөр, талх үйлдвэрлэлт 25.6 хувиар буюу 13.2 сая төгрөгөөр, нарийн боов үйлдвэрлэлт 31.5 хувиар буюу 42.6 сая төгрөгөөр, арматур үйлдвэрлэлт 3.4 хувиар буюу 361.2 сая төгрөгөөр тус тус өссөн бол, нүүрс олборлолт 2.7 хувиар буюу 1163.1 сая төгрөгөөр буурсан

үзүүлэлттэй байна.

НИЙГМИЙН ДААТГАЛ: 2014 оны эхний 7 сарын байдлаар нийгмийн даатгалын сангийн орлого 4856.0 сая төгрөг болж өнгөрсөн оны мөн үеийнхээс орлого 0.2 хувиар буюу 9.3 сая төгрөгөөр, зарлага 9805.5 сая төгрөгт хүрсэн нь 22.3 хувиар буюу 1784.9 сая төгрөгөөр тус тус өссөн байна.



Нийт орлогын 61.6 хувь буюу 2989.2 сая төгрөг тэтгэврийн санд, 6.9 хувь буюу 332.9 сая төгрөг тэтгэмжийн санд, 1.7 хувь буюу 81.2 сая төгрөг ажилгүйдлийн санд, 10.8 хувь буюу 523.0 сая төгрөг ҮОМШӨ санд, 19.1 хувь буюу 929.7 сая төгрөг нь эрүүл мэндийн даатгалын санд тус тус төвлөрсөн байна.

Хүснэгт 3. Нийгмийн даатгалын сан

| Үзүүлэлт | 2013 он | | 2014 он | |
|------------------------|-----------|------------|-----------|------------|
| | Хүний тоо | Сая төгрөг | Хүний тоо | Сая төгрөг |
| Сангийн орлого бүгд | | 4846.7 | | 4856.0 |
| үүнээс: тэтгэврийн сан | | 3133.3 | | 2989.2 |
| тэтгэмжийн сан | | 325.3 | | 332.9 |
| ажилгүйдлийн сан | | 79.3 | | 81.2 |
| ҮОМШӨ-ний сан | | 378.2 | | 523.0 |
| ЭМД-ын сан | | 930.6 | | 929.7 |
| Сангийн зарлага бүгд | | 8020.6 | | 9805.5 |
| үүнээс: тэтгэврийн сан | 3292 | 5184.3 | 7146 | 6277.7 |
| тэтгэмжийн сан | 1562 | 318.7 | 3450 | 412.7 |
| ажилгүйдлийн сан | 213 | 99.7 | 217 | 103.6 |
| ҮОМШӨ-ний сан | 802 | 1076.1 | 1450 | 1083.8 |
| ЭМД-ын сан | 57309 | 1341.8 | 130682 | 1927.7 |

Тайлант хугацаанд 7146 хүнд 6277.7 сая төгрөгийн тэтгэвэр, 3450 хүнд 412.7 сая төгрөгийн тэтгэмж, 1450 хүнд 1083.8 сая төгрөгийн үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний тэтгэмж, 130682 хүнд 1927.7 сая төгрөгийн эрүүл мэндийн даатгал, 217 хүнд 103.6 сая төгрөгийн ажилгүйдлийн тэтгэмжийг тус тус олгосон байна.

НИЙГМИЙН ХАЛАМЖ: 2014 оны эхний 7 сарын байдлаар нийгмийн халамжийн сангийн 22.1 хувь буюу 323.4 сая төгрөг улсын төсвийн, 77.8 хувь буюу 1136.2 сая төгрөг орон нутгийн төсвийн, 0.1 хувь буюу 0.7 сая төгрөг бусад орлогоор санхүүжигдсэн байна.



Хүснэгт 4. Нийгмийн халамжийн сангийн орлого, зарлага


| Үзүүлэлт | Мян төг | Хүний тоо |
|---|-----------|-----------|
| Нийгмийн халамжийн сан бүгд | 1460380.8 | |
| үүнээс улсын төсвөөс | 323400.0 | |
| орон нутгийн төсвөөс | 1136232.6 | |
| бусад орлого | 748.2 | |
| Нийгмийн халамжийн сангийн зарлага бүгд | 1416713.0 | 7852 |
| үүнээс:Тэтгэвэр | 425860.7 | 537 |
| Тэтгэмж | 195549.6 | 491 |
| Жирэмсэн эхчүүдийн тэтгэмж | 214889.7 | 775 |
| Ахмад дайчин, гавьяатын нэмэгдэл | 25957.2 | 27 |
| "Алдарт эх" 1 одонтой эхчүүд | 150800.0 | 754 |
| "Алдарт эх" 2 одонтой эхчүүд | 124900.0 | 1249 |
| Ахмад настанд үзүүлсэн хөнгөлөлт | 186444.6 | 1781 |
| ХБИргэнд үзүүлсэн хөнгөлөлт | 28444.1 | 171 |
| ОНО-д түшиглэсэн халамжийн үйлчилгээ | 27586.0 | 1212 |
| Бусад үйлчилгээ | 36281.1 | 855 |

Тайлант хугацаанд халамжийн сангаас 537 хүнд 452.7 сая төгрөгийн тэтгэвэр, 491 хүнд 195.5 сая төгрөгийн тэтгэмж, 775 жирэмсэн эхчүүдэд 214.9 сая төгрөгийн тэтгэмж, 27 ахмад дайчин, гавьяат цолтой хүнд 25.9 сая төгрөг, алдарт эхийн одонтой 2003 эхчүүдэд 275.7 сая төгрөг, 1781 ахмад настанд 186.4 сая төгрөг, 171 хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд 28.4 сая төгрөгийн хөнгөлөлт тус тус олгосон байна.

Харин олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд 1212 иргэн хамрагдаж 27.6 сая төгрөг хүртсэн байна.

НИЙТИЙН ҮЙЛЧИЛГЭЭ: Энэ оны эхний 7 сарын байдлаар нийтийн аж ахуй үйлчилгээний салбарын нийт орлого 685.8 сая төгрөг болж өнгөрсөн оны мөн үеийнхээс 15.1 хувиар буюу 90.2 сая төгрөгөөр өссөн байна. Мөн нийт орлогын 500.5 сая төгрөг буюу 72.9 хувь нь хүн амаас оруулсан орлого эзэлж байна.

Зураг 6. Орлогын төлөвлөгөөний биелэлт



Хүснэгт 5. Орон сууц нийтийн аж ахуйн орлого

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | 2013 он | 2014 он | Өсөлт бууралт |
|--------------------|----------|----------|---------------|
| Орон сууц | 135971.6 | 164383.0 | 28411.4 |
| Ус борлуулалт-бүгд | 267025.1 | 260599.2 | -6425.9 |
| үүнээс: хүн амд | 162886.6 | 169221.0 | 6334.4 |
| аж ахуйн нэгжид | 99944.8 | 88194.1 | -11750.7 |

| | | | |
|---------------------------|-----------------|-----------------|----------------|
| үйлчилгээний байгууллагад | 4193.7 | 3184.0 | -1009.7 |
| Сувагжуулалт | 241943.0 | 233322.8 | -8620.2 |
| Бусад | 27209.4 | 27464.5 | 255.1 |
| Дүн | 595599.3 | 685769.5 | 90170.2 |

СУУЦ ӨМЧЛӨГЧДИЙН ХОЛБОО: Тайлант хугацаанд дүүргийн СӨХ-дын орлогын төлөвлөгөөний биелэлт доорх байдалтай байна.

Хүснэгт 6. Сууц өмчлөгчдийн холбоодын орлогын байдал /мянган төгрөг/

| Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | ТБ% |
|-----------------|-----------------|-----------------|--------------|
| Тавлаг өргөө | 36448.7 | 36211.2 | 99.3 |
| Маргад өргөө | 31430.0 | 30142.2 | 95.9 |
| Сод хөгжил | 33727.0 | 43616.3 | 129.3 |
| Шинэ элч | 35202.7 | 33875.1 | 96.2 |
| Уурхайчин | 29348.0 | 24443.5 | 83.3 |
| НИЙТ ДҮН | 166156.4 | 168288.3 | 101.3 |

ЭРҮҮЛ МЭНД: Дүүргийн эрүүл мэндийн нэгдлийн мэдээлснээр энэ оны эхний 7 сарын байдлаар дүүрэгт 506 эх амаржиж, 512 хүүхэд төрүүлснээс гадны 75 эх амаржсан байна. Тайлант хугацаанд 145170 хүн амбульторын үзлэгт хамрагдсан нь өнгөрсөн оны мөн үеэс 18241 хүнээр буюу 14.4 хувиар, 3967 хүн хэвтэн эмчлүүлсэн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 100 хүнээр буюу 2.6 хувиар тус тус өссөн байна.

Хүснэгт 7. Бүртгэгдсэн халдварт өвчин

| Үзүүлэлт | 2013 он | 2014 он | Өсөлт бууралт | |
|------------------------|----------------------------|------------|---------------|-------------|
| Халдварт паразит өвчин | 209 | 173 | -36 | |
| Үүнээс: | Заг хүйтэн | 69 | 37 | -32 |
| | Тэмбүү | 58 | 59 | 1 |
| | Мөөгөнцөр | - | 7 | 7 |
| | Трихомноз | 35 | 41 | 6 |
| | Сүрьеэ | 34 | 23 | -11 |
| | Кандидоз | 13 | 6 | -7 |
| Цочмог халдварт өвчин | 157 | 81 | -76 | |
| Үүнээс: | Цусан суулга | 12 | 15 | 3 |
| | Гепатит А | 18 | 5 | -13 |
| | Салхин цэцэг | 28 | 52 | 24 |
| | Гахай хавдар | 82 | 3 | -79 |
| | Сальмонеллез | 1 | | -1 |
| | Роже | 2 | 3 | 1 |
| | Хачигт ректиоз | | 2 | 2 |
| | Гар хөл амны өвчин | 13 | 3 | -10 |
| | Скарлатин | 1 | | -1 |
| | Нийт халдварт өвчин | 366 | 256 | -110 |

Зураг 7. Халдварт өвчин /сараар/




Энэ оны эхний 7 сарын байдлаар халдварт өвчний 256 тохиолдол гарсан нь өнгөрсөн оны мөн үеэс 110 тохиолдлоор буюу 30.1 хувиар буурсан байна. Дүүргийн дунджаар 10000 хүн тутамд ногдох халдварт өвчнөөр өвчлөгсдийн тоо 93.3 процидмилль болсон нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 41.1 пунктээр буурсан байна.

Энэ хугацаанд халдварт паразит өвчин 173 болж нийт халдварт өвчний 68.1 хувийг эзэлж байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 36 тохиолдлоор буюу 17.2 хувиар, цочмог халдварт өвчин 81 тохиолдол байгаа нь нийт халдварт өвчний 31.9 хувийг эзэлж, өнгөрсөн оны мөн үеэс 76 тохиолдлоор буюу 48.4 хувиар тус тус буурсан байна.

ГЭМТ ХЭРЭГ: 2014 оны эхний 7 сарын байдлаар дүүрэгт бүртгэгдсэн нийт гэмт хэргийн тоо 142 байгаа нь өмнөх оны мөн үеэс 21.1 хувиар буюу 38 хэргээр буурсан байна. Мөн хэрэг илрүүлэлт 69.2 хувьтай байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 12.4 пунктээр нэмэгдсэн байна.

Зураг 8. Бүртгэгдсэн гэмт хэрэг /сараар/



Хүснэгт 8. Бүртгэгдсэн гэмт хэрэг, төрлөөр

| Хэргийн төрөл | Хэргийн тоо | | Хэргийн өсөлт | Дүнд эзлэх хувь |
|----------------------|-------------|----------|---------------|-----------------|
| | 2013 он | 2014 он | | |
| Хүн амь | - | 1 | 1 | 0.7 |
| Хүчин | 6 | 1 | -5 | 0.7 |
| Дээрэм | 5 | 4 | -1 | 2.8 |
| Танхай | 6 | 6 | - | 4.2 |
| ББМГУчруулах | 73 | 72 | -1 | 50.7 |
| Ашиглах | 3 | - | -3 | - |
| Хулгай | 40 | 21 | -19 | 14.8 |
| <i>үүнээс: малын</i> | <i>10</i> | <i>1</i> | <i>-9</i> | <i>4.8*</i> |
| Булаалт | - | - | - | - |
| Залилан | 6 | - | -6 | - |
| ХАБЭсрэг | 10 | 9 | -1 | 6.3 |
| Гал түймэр | - | - | - | - |
| Бусад | 31 | 28 | -3 | 19.7 |
| Бүгд | 180 | 142 | -38 | 100.0 |
| Хэрэг илрүүлэлт | 56.8% | 69.2% | | |

*-малын хулгайн хэргийг нийт хулгайн хэрэгт эзлэх хувиар тооцсон.

Нийт бүртгэгдсэн гэмт хэргийн бүтцийг авч үзэхэд дийлэнх хувийг буюу 50.7 хувийг бусдын бие махбодид гэмтэл учруулах /ББМГУчруулах/ хэрэг, 14.8 хувийг хулгайн хэрэг, 19.7 хувийг бусад хэргүүд, 6.3 хувийг хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг хэргүүд тус тус эзэлж байна. Малын хулгайн гэмт хэрэг 1 бүртгэгдсэн нь бүртгэгдсэн хулгайн хэргийн 4.8 хувийг эзэлж байна. Тайлант хугацаанд ашиглах, булаалт, залилангийн болон гал түймрийн хэргүүд бүртгэгдээгүй байна.

Зураг 9. Согтуугаар болон гудамж талбайд үйлдэгдсэн гэмт хэрэг



Хүснэгт 9. Согтуугаар болон гудамж талбайд үйлдэгдсэн гэмт хэрэг

| Хэргийн төрөл | 2013 он | | 2014 он | |
|-----------------|------------|----------------|------------|----------------|
| | согтуугаар | гудамж талбайд | согтуугаар | гудамж талбайд |
| Хүн амь | - | - | 1 | - |
| Хүчин | 1 | - | - | 1 |
| Дээрэм | 3 | 4 | 4 | 1 |
| Танхай | 6 | 5 | 5 | 1 |
| ББМГУчруулах | 47 | 27 | 42 | 22 |
| Хулгай | 3 | 2 | 3 | 2 |
| Залилан | - | 1 | - | - |
| ХАБЭсрэг | 3 | 1 | 2 | - |
| Бусад | 5 | 5 | 10 | 8 |
| Бүгд | 68 | 45 | 67 | 35 |
| Дүнд эзлэх хувь | 37.8% | 25.0% | 47.2% | 24.6% |

Зураг 10. Согтуугаар болон гудамж талбайд үйлдэгдсэн гэмт хэрэг



2014 оны эхний 7 сарын байдлаар согтуугаар үйлдэгдсэн гэмт хэргийн тоо 67 байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 1.5 хувиар буюу 1 хэргээр буурсан байна. Энэ нь тайлант хугацаанд бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 47.2 хувийг эзэлж байгаа бөгөөд нийт гэмт хэрэгт эзлэх хувь өнгөрсөн оны мөн үеэс 9.4 пунктээр нэмэгдсэн байна.

Тайлант хугацаанд гудамж талбайд үйлдэгдсэн гэмт хэргийн тоо 35 болж өнгөрсөн оны мөн үеэс 22.2 хувиар буюу 10 хэргээр буурсан нь нийт гэмт хэргийн 24.6 эзэлж, өнгөрсөн оноос 0.4 пунктээр буурсан байна.

БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД: Оны эхний 7 сарын байдлаар дүүрэгт ажил идэвхтэй хайж байгаа ажилгүй иргэд 393 байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 18.3 хувиар буюу 88 хүнээр, эмэгтэй ажилгүй иргэд 236 байгаа нь өмнөх оны мөн үеэс 3.3 хувиар буюу 8 хүнээр тус тус буурсан байна.

Зураг 11. Бүртгэлтэй ажилгүй иргэдийн хөдөлгөөн



Тайлант сард бүртгэлээс хасагдсан 113 иргэн байхад ажил идэвхтэй хайж байгаа 149 иргэн шинээр бүртгүүлсэн бөгөөд үүний 63.7 хувь нь буюу 95 нь эмэгтэйчүүд байна. Харин 40 иргэн ажилд зуучлуулан орсон ба үүнээс:

- Хязгаарлагдмал хариуцлагатай компанид – 18
- Бусад байгууллагад – 22 иргэн ажилд орсон байна.

Хүснэгт 10. Бүртгэлтэй ажилгүй иргэд, насны бүлгээр:

| Үзүүлэлт | 2013 он | Дүнд эзлэх хувь | 2014 он | Дүнд эзлэх хувь |
|-----------|---------|-----------------|---------|-----------------|
| 16-24 нас | 150 | 31.2 | 145 | 36.9 |
| 25-34 нас | 155 | 32.2 | 103 | 26.2 |
| 35-44 нас | 104 | 21.6 | 56 | 14.2 |
| 45-60 нас | 72 | 15.0 | 89 | 22.6 |
| Бүгд | 481 | 100.0 | 393 | 100.0 |

2014 оны 7 сарын байдлаар ажил идэвхтэй хайж байгаа бүртгэлтэй ажилгүй иргэдийг насны бүлгээр харахад 36.9 хувь нь 16-24 насны, 25.2 хувь нь 25-34 насны, 14.2 хувь нь 35-44 насны, 22.6 хувь нь 45-60 насны ажилгүй иргэд эзэлж байна.

Хүснэгт 11. Бүртгэлтэй ажилгүй иргэд, боловсролоор:

| Үзүүлэлт | Ажилгүй иргэд | | Бүгдэд эзлэх хувь | | |
|--------------------------|------------------------|---------|-------------------|---------|------|
| | 2013 он | 2014 он | 2013 он | 2014 он | |
| Бүртгэлтэй ажилгүй иргэд | 481 | 393 | 100.0 | 100.0 | |
| Үүнээс | Дээд | 144 | 121 | 29.9 | 30.8 |
| | Тусгай дунд | 51 | 40 | 10.6 | 10.2 |
| | Мэргэжлийн анхан шатны | 35 | 38 | 7.3 | 9.7 |
| | Бүрэн дунд | 215 | 157 | 44.7 | 39.9 |
| | Бүрэн бус дунд | 28 | 21 | 5.8 | 5.3 |
| | Бага | 6 | 11 | 1.2 | 2.8 |
| | Боловсролгүй | 2 | 5 | 0.4 | 1.3 |

Тайлант сарын байдлаар ажил идэвхтэй хайж байгаа ажилгүй иргэдийг боловсролын түвшингээр ангилж үзэхэд 30.8 хувийг дээд, 10.2 хувийг тусгай дунд, 9.7 хувийг мэргэжлийн анхан шатны, 39.9 хувийг бүрэн дунд, 5.3 хувийг бүрэн бус дунд, 2.8 хувийг бага боловсролтой 1.3 хувийг боловсролгүй иргэд эзэлж байна.

Зураг 12. Бүртгэлтэй ажилгүй иргэд /боловсролоор/



ҮНЭ ХАНШ: 2014 оны 7-р сарын хүнсний өргөн хэрэглээний 19 нэр төрлийн бүтээгдэхүүний дундаж үнийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад дараах байдалтай байна.

Хүснэгт 12. Өргөн хэрэглээний барааны дундаж үнэ /жил бүрийн 7 сарын байдлаар/

| Барааны нэр төрөл | Хүн | 2011 | 2012 | 2013 | 2014 | 2014 % 2013 |
|----------------------------------|-----|------|------|------|------|----------------|
| 1. Гурил /дээд/ | кг | 981 | 925 | 1100 | 1150 | 104.5 |
| 2. Гурил 1-р зэрэг /алтан тариа/ | кг | 750 | 750 | 765 | 800 | 104.6 |
| 3. Гурил 2-р зэрэг /алтан тариа/ | кг | 569 | 525 | 575 | 600 | 104.3 |
| 4. Цагаан будаа | кг | 1644 | 1700 | 1750 | 2200 | 125.7 |
| 5. Шар будаа | кг | 1650 | 1487 | 1600 | 1500 | 93.8 |
| 6. Хонины мах | кг | 4138 | 7535 | 8188 | 8000 | 97.7 |
| 7. Үхрийн мах | кг | 4913 | 8294 | 9063 | 9625 | 106.2 |
| 8. Сүү | л | 438 | 500 | 600 | 650 | 108.3 |
| 9. Тараг | л | 675 | 750 | 900 | 1050 | 116.7 |
| 10. Цөцгийн тос | кг | 3025 | 3000 | 3000 | 3100 | 103.3 |
| 11. Элсэн чихэр | кг | 1613 | 1663 | 1600 | 1600 | 100.0 |
| 12. Монгол төмс | кг | 1000 | 913 | 775 | 1450 | 187.1 |
| 13. Байцаа | кг | 1000 | 968 | 1000 | 1350 | 135.0 |
| 14. Монгол лууван | кг | 1500 | 1475 | 1875 | 2033 | 108.4 |
| 15. Манжин | кг | 3375 | 1412 | 2125 | 1500 | 70.6 |
| 16. Хятад бөөрөнхий сонгино | кг | 1000 | 1000 | 1200 | 1200 | 100.0 |
| 17. Монгол сонгино | кг | 3000 | 3500 | 2875 | 1500 | 52.2 |
| 18. Ургамлын тос | ш | 2700 | 2850 | 3050 | 3575 | 117.2 |
| 19. Өндөг | ш | 224 | 270 | 270 | 350 | 129.6 |

Зураг 13. "Алтан тариа" гурилын үнэ



Зураг 14. Нэг кг махны дундаж үнэ



Хүснэгт 13. Үйлчилгээний үнийн тариф /НӨАТ-гүй үнэ/

| Үзүүлэлт | Айл өрхөд | Аж ахуйн нэгж байгууллагад |
|---------------------|--|---|
| Дулаан | 1 м ² =341 төг | 1м ³ =697 төг |
| Дулааны суурь тариф | 40 м ² хүртлэх=3000 төг 40м ² - 80м ² = 5000 төг 80м ² –аас дээш = 10000 төг | - |
| Халуун ус | Өвөл 1 хүн=1282 төг /тоолуургүй/ 1м ³ =700 төг /тоолууртай / | 1гкал=41147 төг |
| | Зун 1 хүн=1924 төг /тоолуургүй/ 1м ³ =1050 төг /тоолууртай / | |
| Цэвэр ус* | 1 хүн=5106 төг /тоолуургүй/ 1 л=0.63 төг /тоолууртай/ Суурь хураамж =1800 төг | 1 л=1.20 төг /тоолуургүй/ 1 л=1.15 төг /тоолууртай/ 1 л=4.41 төг /зөөврөөр/ |
| Бохир ус* | 1 хүн=4830 төг /тоолуургүй/ 1 л=0.58 төг /тоолууртай/ | 1 л=1.20 төг /тоолуургүй/ 1 л=1.15 төг/тоолууртай/ |

*2014 оны 7 сарын 15-ны өдрөөс мөрдөж буй тариф

Хүснэгт 14. Түлш, шатахууны үнэ

| Шатахууны нэр төрөл | 2012 он | 2013 он | 2014 он | өөрчлөлт | |
|---------------------|---------|---------|---------|----------|------|
| | | | | төгрөг | хувь |
| АИ - 76 | 1470 | 1520 | 1560 | 40 | 2.6 |
| АИ - 92 | 1610 | 1660 | 1700 | 40 | 2.4 |
| Дизель түлш | 1740 | 1790 | 1830 | 40 | 2.2 |

2014 оны 7-р сард түлш, шатахууны үнэ тогтвортой байсан бөгөөд өнгөрсөн оны мөн үеэс төрөл тус бүр литр тутамдаа 40 төгрөгөөр буюу 2.2 - 2.6 хувиар тус тус өссөн байна.

Зураг 15. Хот хоорондын зорчигч тээврийн үнэ /УБ-БН, БН-УБ/



Хүснэгт 15. Цахилгааны үнийн тариф /НӨТ-гүй үнэ/

| Хэрэглэгчдийн ангилал | Хэмжих нэгж | Тариф /НӨАТ-гүй/ |
|---|-------------|------------------|
| <i>* Айл өрхөд борлуулах цахилгааны тариф</i> | | |
| Энгийн тоолууртай | | |
| Сарын нийт хэрэглээний 150 кВт.ц | төг/квт.ц | 79.0 |
| Сарын нийт хэрэглээний 151 кВт.ц-аас дээш | төг/квт.ц | 96.6 |
| 2 тарифт тоолууртай | | |
| Өдрийн хэрэглээ /06.00-21.00/ | төг/квт.ц | 84.0 |
| Орой, шөнийн хэрэглээ /21.00-06.00/ | төг/квт.ц | 60.0 |
| Сарын суурь тариф | төг/сар | 1000.0 |
| <i>* Аж ахуйн нэгж, байгууллагад борлуулах цахилгааны тариф</i> | | |
| Энгийн тоолууртай | төг/квт.ц | 105.6 |
| 3 тарифт тоолууртай | | |
| Өдрийн хэрэглээ /06.00-17.00/ | төг/квт.ц | 105.6 |
| Оройн хэрэглээ /17.00-24.00/ | төг/квт.ц | 178.6 |
| Шөнийн хэрэглээ /24.00-06.00/ | төг/квт.ц | 60.0 |

СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

2014 оны 8 дугаар сарын 7